

**БАЙГАЛЬ ОРЧИН, ХҮНС, ХӨДӨӨ АЖ АХУЙН БАЙНГЫН ХОРООНЫ  
ХУРАЛДААНЫ ТЭМДЭГЛЭЛИЙН АГУУЛГА  
2026 оны 06 дугаар сарын 10-ны өдөр, Лхагва гараг**

**Хуралдааны тэмдэглэлийн агуулга**

<b>Хуралдааны товч тэмдэглэл:</b>	1-9
<b>Хуралдааны дэлгэрэнгүй тэмдэглэл:</b>	10-18
<hr/>	
1.Хүнсний тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүд /Улсын Их Хурлын гишүүн М.Мандхай нарын 10 гишүүн 2025.06.19 -ний өдөр өргөн мэдүүлсэн, анхны хэлэлцүүлэг/	11-17
2.Хөдөө аж ахуйн тухай хуулийн төсөл /Улсын Их Хурлын гишүүн М.Мандхай нарын 10 гишүүн 2025.06.19-ний өдөр өргөн мэдүүлсэн, эцсийн хэлэлцүүлэг/	17-18

**Монгол Улсын Их Хурлын 2026 оны хаврын ээлжит чуулганы  
Байгаль орчин, хүнс, хөдөө аж ахуйн байнгын хорооны  
06 дугаар сарын 10-ны өдөр /Лхагва гараг/-ийн  
хуралдааны товч тэмдэглэл**

Байгаль орчин, хүнс, хөдөө аж ахуйн байнгын хорооны дарга Б.Бейсен ирц, хэлэлцэх асуудлын дарааллыг танилцуулж, хуралдааныг даргалав.

Хуралдаанд ирвэл зохих 29 гишүүнээс 16 гишүүн хүрэлцэн ирж, 55.2 хувийн ирцтэйгээр хуралдаан 14 цаг 05 минутад Төрийн ордны “Их засаг” танхимд эхлэв.

Томилолттой: Д.Батбаяр, Ж.Бат-Эрдэнэ, С.Ганбаатар, С.Лүндээ;  
Чөлөөтэй: Д.Амарбаясгалан, С.Амарсайхан, О.Амгаланбаатар,  
Б.Батцэцэг, Х.Ганхуяг, С.Замира, Р.Сэддорж, Ц.Туваан, А.Ундраа.

Улсын Их Хурлын гишүүн Б.Бейсен хэлэлцэх асуудлын дарааллын 3 дугаарт орсон “Ажлын хэсэг байгуулах тухай” Байнгын хорооны тогтоолын төслийг хэлэлцэх асуудлаас хасах горимын санал гаргав.

**Б.Бейсен:** Улсын Их Хурлын гишүүн Б.Бейсений гаргасан горимын саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулья.

Зөвшөөрсөн:	12
Татгалзсан:	4
Бүгд:	16

75.0 хувийн саналаар горимын санал дэмжигдлээ.

**Нэг.Хүнсний тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүд /Улсын Их Хурлын гишүүн М.Мандхай нарын 10 гишүүн 2025.06.19-ний өдөр өргөн мэдүүлсэн, анхны хэлэлцүүлэг/**

Хэлэлцэж буй асуудалтай холбогдуулан Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн яамны Хүнсний үйлдвэрийн бодлогын хэрэгжилтийг зохицуулах газрын дарга Д.Довчинсүрэн, мөн яамны Бодлого, төлөвлөлтийн газрын дарга Ц.Болорчулуун, мөн газрын ахлах шинжээч О.Онон, ахлах мэргэжилтэн Х.Цэрэнханд, Хуулийн хэлтсийн дарга Ч.Раднаабазар, Хүнсний эрдэм шинжилгээ, судалгааны хүрээлэнгийн захирал М.Пүрэвжав, хуульч Я.Хишигт нар оролцов.

Хуралдаанд Улсын Их Хурлын Тамгын газрын Байнгын хороодын асуудал эрхлэх газрын Байгаль орчин, хүнс, хөдөө аж ахуйн байнгын хорооны ажлын албаны ахлах зөвлөх Ш.Ариунжаргал, зөвлөх П.Хулан, референт Б.Бадралт, Ц.Рэнцэнтогтох, Б.Энхгэрэл нар байлцав.

Хуулийн төслийн талаарх тусгайлсан ажлын хэсгийн саналыг ажлын хэсгийн ахлагч, Улсын Их Хурлын гишүүн Т.Мөнхсайхан танилцуулав.

Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 39 дүгээр зүйлийн 39.10-т заасны дагуу Хүнсний тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг зүйл бүрээр хэлэлцэв.

*Төслийн зүйлүүдтэй холбогдуулан ажлын хэсгийн гаргасан зарчмын зөрүүтэй саналын томъёоллоор санал хураалт явуулав.*

**Б.Бейсен:** 1.Улсын Их Хурлын гишүүн Т.Мөнхсайхан, П.Батчимэг, Г.Ганбаатар, Н.Наранбаатар, А.Ундраа, Б.Уянга /цаашид “Ажлын хэсэг” гэх/ нарын гаргасан, Төслийн 1 дүгээр зүйлийн 1 дэх заалт буюу 3.1.15 дахь заалтыг доор дурдсан саналаар өөрчлөн найруулж, 3.1.14 дэх заалт болгож, 3.1.16 дахь заалтыг, мөн зүйлийн 2 дахь заалтыг тус тус хасах:

“3.1.14.“хоол үйлдвэрлэл, үйлчилгээ” гэж стандартын шаардлага хангасан байр, түүхий эд, бүтээгдэхүүн ашиглан, жор, технологийн дагуу техник, тоног төхөөрөмж, мэргэжлийн хүний нөөцөд тулгуурлан хоол үйлдвэрлэх, түүгээр үйлчлэх үйл ажиллагааг.” гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 13

Татгалзсан: 3

Бүгд: 16

81.3 хувийн саналаар дэмжигдлээ.

2.Ажлын хэсгийн гаргасан, Төслийн 1 дүгээр зүйлийн 4 дэх заалт буюу 4.2.1 дэх заалтын “хүртээмжийн” гэснийг “хүртээмж, дотоодын үйлдвэрлэлийн” гэж, 4.2.2 дахь заалтын “баталгаат” гэснийг “аюулгүй” гэж, 4.2.4 дэх заалтын “салбарын” гэснийг “аюулгүй байдлыг хангах” гэж өөрчилж, 4.3, 4.4 дэх хэсгийг хасах гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 12

Татгалзсан: 4

Бүгд: 16

75.0 хувийн саналаар дэмжигдлээ.

3.Ажлын хэсгийн гаргасан, Төслийн 1 дүгээр зүйлийн 5 дахь заалтыг хасаж, мөн зүйлийн 4 дэх заалтад доор дурдсан агуулгатай 4.3 дахь хэсэг нэмэх:

“4.3.Энэ хуулийн 4.2 дахь хэсэгт заасан хүнсний аюулгүй байдлын бодлогыг удирдлага, зохион байгуулалт, хүний нөөц, мэдээлэл болон эрсдэлийн удирдлага, хяналтаар дамжуулан хэрэгжүүлнэ.” гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 13

Татгалзсан: 3

Бүгд: 16

81.3 хувийн саналаар дэмжигдлээ.

4.Ажлын хэсгийн гаргасан, Төслийн 6 дахь заалт буюу 4<sup>2</sup> дугаар зүйлийн 4<sup>2</sup>.1 дэх хэсгийн “мэргэшүүлэх, хөгжүүлэхэд,” гэснийг “мэргэшүүлэхэд” гэж, “хүнс, хөдөө аж ахуйн асуудал хариуцсан” гэснийг “хүнсний асуудал эрхэлсэн” гэж өөрчилж, “нөөцийн эрэлт хэрэгцээний судалгааг тогтмол хийж, хүний” гэснийг, 4<sup>2</sup>.2 дахь хэсгийн “боловсролын асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага,” гэснийг тус тус хасаж, 4<sup>2</sup>.3, 4<sup>2</sup>.4, 4<sup>2</sup>.5, 4<sup>2</sup>.7, 4<sup>2</sup>.8, 4<sup>2</sup>.9 дэх хэсгийг нэгтгэж, доор дурдсанаар өөрчлөн найруулж, 4<sup>2</sup> дугаар зүйлийн дугаарыг 13<sup>2</sup> дугаар зүйл гэж өөрчлөх:

“4<sup>2</sup>.3.Хүнсний салбарын мэргэжлийн зэрэг олгох журмыг хүнсний асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн батална.

4<sup>2</sup>.4.Энэ хуулийн 4<sup>2</sup>.3-т заасан журамд мэргэжлийн зэргийн төрөл, хэлбэр, хугацаа, мэргэшүүлэх чиглэл, тавих шаардлага, сургалтын багц цаг болон зэрэг олгох, сунгах, түдгэлзүүлэх, сэргээх, хүчингүй болгохтой холбоотой харилцааг тусгана.

4<sup>2</sup>.5.Энэ хуулийн 4<sup>2</sup>.4-т заасан мэргэжлийн зэрэг олгох, сунгах, түдгэлзүүлэх, сэргээх, хүчингүй болгох шийдвэрийг хүнсний асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага гаргах бөгөөд мэргэжилтэн уг шийдвэрийн талаар хуульд заасан журмын дагуу гомдол гаргах эрхтэй.” гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 11  
Татгалзсан: 5  
Бүгд: 16  
68.8 хувийн саналаар дэмжигдлээ.

5.Ажлын хэсгийн гаргасан, Төслийн 1 дүгээр зүйлийн 7 дахь заалт буюу 5.6 дахь хэсгийн “хүртээмжтэй байлгана” гэснийг “хүртээмжтэй байлгах арга хэмжээг Засгийн газар авч хэрэгжүүлнэ.” гэж өөрчилж, 5.5 дахь хэсгийг, 5.8 дахь заалтын “тусгайлсан” гэснийг тус тус хасах гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 11  
Татгалзсан: 5  
Бүгд: 16  
68.8 хувийн саналаар дэмжигдлээ.

6.Ажлын хэсгийн гаргасан, Төслийн 1 дүгээр зүйлийн 8, 9 дэх заалтыг тус тус хасах гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 12  
Татгалзсан: 4  
Бүгд: 16  
75.0 хувийн саналаар дэмжигдлээ.

7.Ажлын хэсгийн гаргасан, Төслийн 1 дүгээр зүйлийн 8.1.8 дахь заалтыг доор дурдсанаар өөрчлөн найруулах:

“8.1.8.цэцэрлэг, сургуулийн хүүхдийн хоол үйлдвэрлэлд дотоодын гарал үүсэлтэй түүхий эд ашиглан, стандарт, техникийн зохицуулалтын шаардлага хангасан үйлдвэрт бэлтгэсэн хагас боловсруулсан болон бэлэн бүтээгдэхүүн нийлүүлсэн аж ахуйн нэгж, хоршоонд;” гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 12  
Татгалзсан: 4  
Бүгд: 16

75.0 хувийн саналаар дэмжигдлээ.

8.Ажлын хэсгийн гаргасан, Төслийн 1 дүгээр зүйлийн 10 дахь заалт буюу 10.5 дахь хэсгийг доор дурдсанаар өөрчлөн найруулж, 10.4.3 дахь заалт болгох:

“10.4.3.хүнсний экспорт, импорт, шошгололт, хадгалалт, хүргэлт, цахим болон бусад худалдаанд.” гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 12

Татгалзсан: 4

Бүгд: 16

75.0 хувийн саналаар дэмжигдлээ.

9.Ажлын хэсгийн гаргасан, Төслийн 1 дүгээр зүйлийн 11 дэх заалт буюу 13.1.6 дахь заалтын “баталгаат” гэснийг “бүтээгдэхүүний аюулгүй” гэж өөрчилж, мөн зүйлийн 12 дахь заалтыг хасах гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 10

Татгалзсан: 6

Бүгд: 16

62.5 хувийн саналаар дэмжигдлээ.

10.Ажлын хэсгийн гаргасан, Төслийн 1 дүгээр зүйлийн 13 дахь заалтын 13<sup>2</sup>.3.8 дахь заалтын “баталгаат” гэснийг “аюулгүй” гэж, “олон нийтэд сургалт, сурталчилгаа, соён гэгээрүүлэх” гэснийг “олон нийтийг соён гэгээрүүлэх сургалт, сурталчилгааны” гэж өөрчилж, 13<sup>2</sup>.3.9 дэх заалтын “таван жил” гэсний өмнө “гурваас” гэж нэмж, 13<sup>2</sup>.3.6 дахь заалтын “өндөр хөгжилтэй орны” гэснийг, 13<sup>2</sup>.3.7 дахь заалтын “мэргэжилтэн болон хүнсний чиглэлийн үйл ажиллагаа эрхэлдэг хуулийн этгээдийн” гэснийг, 13<sup>2</sup>.3.10 дахь заалтыг тус тус хасах гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 11

Татгалзсан: 5

Бүгд: 16

68.8 хувийн саналаар дэмжигдлээ.

11.Ажлын хэсгийн гаргасан, Төслийн 1 дүгээр зүйлийн 14 дэх заалт буюу 17<sup>1</sup> дүгээр зүйлийг доор дурдсанаар өөрчлөн найруулах:

**“17<sup>1</sup> дүгээр зүйл.Хүнсний салбарын мэдээллийн нэгдсэн сан**

17<sup>1</sup>.1.Хүнсний асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага хүнсний аюулгүй байдлыг хангах, салбар хоорондын үйл ажиллагааг уялдуулан зохицуулах зорилгоор мэдээллийн нэгдсэн сан үүсгэж, эрхлэн хөтөлнө.

17<sup>1</sup>.2.Хүнсний салбарын мэдээллийн нэгдсэн сан нь дараах мэдээллээс бүрдэнэ:

17<sup>1</sup>.2.1.хүнсний чиглэлийн үйл ажиллагаа эрхлэгчийн бүртгэл;

17<sup>1</sup>.2.2.гол нэрийн хүнсний нөөцийн мэдээлэл;

17<sup>1</sup>.2.3.баяжуулагч бэлдмэл, хүнсний нэмэлт, өсгөврийн хөрөнгө, шинэ технологиор үйлдвэрлэсэн хүнс, хувиргасан амьд организмаас гаралтай хүнсний бүртгэл;

17<sup>1</sup>.2.4.хяналт, шалгалтын тайлан;

17<sup>1</sup>.2.5.импорт, экспортын зөвшөөрөл, гүйцэтгэлийн мэдээлэл;

17<sup>1</sup>.2.6.энэ хуулийн 17 дугаар зүйлд заасны дагуу баталгаажуулалт хийсэн талаарх мэдээлэл;

17<sup>1</sup>.2.7.хүнсний сорилтын лабораторийн шинжилгээний дүн;

17<sup>1</sup>.2.8.хүнсний салбарын эрдэм шинжилгээ, судалгааны ажлын тайлан.

17<sup>1</sup>.3.Төрийн болон бусад байгууллагатай цахим хэлбэрээр мэдээлэл солилцох, мэдээллийн санг бүрдүүлэх харилцааг Нийтийн мэдээллийн ил тод байдлын тухай хуулийн 18.10, 27.9-д заасны дагуу зохицуулна.

17<sup>1</sup>.4.Мэдээллийн нэгдсэн санг бүрдүүлэх, мэдээлэл ашиглах, цуглуулах, хэлбэр, хугацаа, мэдээллийн ил тод байдал, нууцлал, аюулгүй байдлыг хангах, хадгалах, хамгаалах, эрхлэн хөтлөхтэй холбогдсон журмыг Засгийн газар батална.” гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 10  
Татгалзсан: 6  
Бүгд: 16  
62.5 хувийн саналаар дэмжигдлээ.

12.Ажлын хэсгийн гаргасан, Дээрх 6 дахь санал дэмжигдсэнтэй холбогдуулан 1 дүгээр зүйлийн 15 дахь заалтыг хасах гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 9  
Татгалзсан: 7  
Бүгд: 16  
56.3 хувийн саналаар дэмжигдлээ.

13.Ажлын хэсгийн гаргасан, Төслийн 2 дугаар зүйлийн “1 дүгээр зүйлийн “зорилт нь” гэсний дараа “хүнсний аюулгүй байдлыг хангаж, хүний эрүүл мэндийг дэмжин хамгаалах зорилгоор” гэж,” гэснийг, “, 9 дүгээр зүйлийн 9.3 дахь хэсгийн “харилцааг” гэсний дараа “тусгайлан” гэж гэж” гэснийг тус тус хасах гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 8  
Татгалзсан: 8  
Бүгд: 16  
50.0 хувийн саналаар дэмжигдсэнгүй.

Улсын Их Хурлын гишүүн У.Отгонбаярын “дэмжсэн” санал “эсрэг” гарсан тул дээрх санал хураалтыг хүчингүй болгож, дахин санал хураалт явуулах горимын санал гаргав.

**Б.Бейсен:** Улсын Их Хурлын гишүүн У.Отгонбаярын гаргасан горимын саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 9  
Татгалзсан: 7  
Бүгд: 16  
56.3 хувийн саналаар горимын санал дэмжигдлээ.

13.Ажлын хэсгийн гаргасан, Төслийн 2 дугаар зүйлийн “1 дүгээр зүйлийн “зорилт нь” гэсний дараа “хүнсний аюулгүй байдлыг хангаж, хүний эрүүл мэндийг дэмжин хамгаалах зорилгоор” гэж,” гэснийг, “, 9 дүгээр зүйлийн 9.3 дахь хэсгийн “харилцааг” гэсний дараа “тусгайлан” гэж гэж” гэснийг тус тус хасах гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалтыг дахин явуулъя.

Зөвшөөрсөн: 9  
Татгалзсан: 7  
Бүгд: 16  
56.3 хувийн саналаар дэмжигдлээ.

14.Ажлын хэсгийн гаргасан, Төслийн 3 дугаар зүйлийн 5<sup>1</sup> дүгээр зүйлийн 5<sup>1.7</sup> дахь хэсгийн “дүгнэлтийг үндэслэн” гэснийг “санал, зөвлөмжийг харгалзан” гэж өөрчилж, 5<sup>1.6</sup> дахь хэсгийг хасах гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 9  
Татгалзсан: 7  
Бүгд: 16  
56.3 хувийн саналаар дэмжигдлээ.

15.Ажлын хэсгийн гаргасан, Дээрх 1, 2, 13 дахь санал дэмжигдсэнтэй холбогдуулан төслийн 4 дүгээр зүйлийг доор дурдсанаар өөрчлөн найруулах:

**“4 дүгээр зүйл.**Хүнсний тухай хуулийн 1 дүгээр зүйлийн 1.1 дэх хэсгийн “эрхлэхтэй” гэснийг “эрхлэх, түүнд хяналт тавихтай” гэж, 3 дугаар зүйлийн 3.1.8 дахь заалтын “үйлдвэрлэсэн” гэснийг “үйлдвэрлэсэн хүнс” гэж, “хийгдсэнийг” гэснийг “хийгдсэн хүнсийг” гэж, 4 дүгээр зүйлийн гарчгийн “зарчим” гэснийг “зарчим, бодлогын чиглэл” гэж, Хоёрдугаар бүлгийн гарчгийн “ХАНГАМЖ” гэснийг “ХАНГАМЖ, ХҮРТЭЭМЖ” гэж, 10 дугаар зүйлийн 10.1.5 дахь заалтын “боловсруулах болон нийтийн хоолны үйлдвэрлэл” гэснийг “хүнсний боловсруулах болон хоол үйлдвэрлэл, үйлчилгээ” гэж, 13 дугаар зүйлийн 13.1.1 дэх заалтын “шим тэжээллэг байдалд” гэснийг “шим тэжээллэг байдал, хуурамч хүнсний бүтээгдэхүүнд гэж” тус тус өөрчилсүгэй.” гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 10  
Татгалзсан: 6

Бүгд: 16  
62.5 хувийн саналаар дэмжигдлээ.

16.Ажлын хэсгийн гаргасан, Дээрх 1, 2, 13, 14 дэх санал дэмжигдсэнтэй холбогдуулан төслийн 5 дугаар зүйлийг хасах гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 10  
Татгалзсан: 6  
Бүгд: 16  
62.5 хувийн саналаар дэмжигдлээ.

17.Ажлын хэсгийн гаргасан, Төслийн 6 дугаар зүйлийн “3 дугаар зүйлийн 3.1.2 дахь заалт, 4 дүгээр зүйлийн 4.1.1,” гэснийг хасах гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 10  
Татгалзсан: 6  
Бүгд: 16  
62.5 хувийн саналаар дэмжигдлээ.

#### **Найруулгын санал:**

**Б.Бейсен:** Ажлын хэсгийн гаргасан, Төслийн талаарх зарчмын зөрүүтэй саналын томьёолол дэмжигдсэнтэй холбогдуулан төслийн бүтэц, нэр, томьёо, хэл найруулга, дэс дараалал, зүйл, заалтын дугаар, эшлэлийг нийцүүлж өөрчлөх гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 10  
Татгалзсан: 6  
Бүгд: 16  
62.5 хувийн саналаар дэмжигдлээ.

*Хуулийн төслийг зүйл бүрээр хэлэлцэж дууслаа.*

*Хүнсний тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөлтэй хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүдийг зүйл бүрээр хэлэлцэв.*

#### **Нэг.Хүнсний бүтээгдэхүүний аюулгүй байдлыг хангах тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл**

*Төслийн зүйлүүдтэй холбогдуулан ажлын хэсгийн гаргасан зарчмын зөрүүтэй саналын томьёоллоор санал хураалт явуулав.*

**Б.Бейсен:** 1.Ажлын хэсгийн гаргасан, Төслийн 1 дүгээр зүйлийн 1 дэх заалтын 4.1.4 дэх заалтын “хүнсний баталгаат байдал” гэснийг “хүнсний түүхий эд, бүтээгдэхүүний аюулгүй байдал” гэж өөрчлөх гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 9  
Татгалзсан: 7

Бүгд: 16  
56.3 хувийн саналаар дэмжигдлээ.

2.Ажлын хэсгийн гаргасан, Төслийн 2 дугаар зүйлийг хасах гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 10  
Татгалзсан: 6  
Бүгд: 16  
62.5 хувийн саналаар дэмжигдлээ.

*Хуулийн төслийг зүйл бүрээр хэлэлцэж дууслаа.*

**Хоёр.Зөрчлийн тухай /Шинэчилсэн найруулга/ хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл**

*Төслийн зүйлүүдтэй холбогдуулан ажлын хэсгийн гаргасан зарчмын зөрүүтэй саналын томъёоллоор санал хураалт явуулав.*

**Б.Бейсен:** Ажлын хэсгийн гаргасан, Төслийн 1 дүгээр зүйлийн “, 6.15 дугаар зүйлийн гарчгийн “Хүнсний бүтээгдэхүүний аюулгүй байдлыг хангах” гэснийг “Хүнсний бүтээгдэхүүний баталгаат байдлыг хангах” гэж, 13.9 дүгээр зүйлийн 2 дахь хэсгийн “бүтээгдэхүүний аюулгүй байдал” гэснийг “бүтээгдэхүүний баталгаат байдал” гэж тус тус” гэснийг хасах гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 10  
Татгалзсан: 6  
Бүгд: 16  
62.5 хувийн саналаар дэмжигдлээ.

*Хуулийн төслийг зүйл бүрээр хэлэлцэж дууслаа.*

Байнгын хорооноос гарах санал, дүгнэлтийг Улсын Их Хурлын гишүүн Т.Мөнхсайхан Улсын Их Хурлын чуулганы нэгдсэн хуралдаанд танилцуулахаар тогтов.

*Уг асуудлыг 14 цаг 40 минутад хэлэлцэж дуусав.*

**Хоёр.Хөдөө аж ахуйн тухай хуулийн төсөл /Улсын Их Хурлын гишүүн М.Мандхай нарын 10 гишүүн 2025.06.19-ний өдөр өргөн мэдүүлсэн, эцсийн хэлэлцүүлэг/**

Хэлэлцэж буй асуудалтай холбогдуулан Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн яамны Бодлого, төлөвлөлтийн газрын дарга Ц.Болорчулуун, мөн яамны Хуулийн хэлтсийн дарга Ч.Раднаабазар нар оролцов.

Хуралдаанд Улсын Их Хурлын Тамгын газрын Байнгын хороодын асуудал эрхлэх газрын Байгаль орчин, хүнс, хөдөө аж ахуйн байнгын хорооны ажлын албаны ахлах зөвлөх Ш.Ариунжаргал, зөвлөх Бад.Баярмаа, референт Б.Бадралт, Ц.Рэнцэнтогтох нар байлцав.

Хуулийн төслийг эцсийн хэлэлцүүлэгт бэлтгэсэн тухай танилцуулгыг ажлын хэсгийн ахлагч, Улсын Их Хурлын гишүүн Н.Наранбаатар танилцуулав.

Танилцуулгатай холбогдуулан Улсын Их Хурлын гишүүдээс асуулт, санал гараагүй болно.

Байнгын хорооноос гарах танилцуулгыг Улсын Их Хурлын гишүүн Н.Наранбаатар Улсын Их Хурлын чуулганы нэгдсэн хуралдаанд танилцуулахаар тогтов.

*Уг асуудлыг 14 цаг 43 минутад хэлэлцэж дуусав.*

Байнгын хорооны хуралдаанаар 2 асуудал хэлэлцэв.

*Хуралдаан 38 минут үргэлжилж, ирвэл зохих 29 гишүүнээс 16 гишүүн хүрэлцэн ирж, 55.2 хувийн ирцтэйгээр 14 цаг 43 минутад өндөрлөв.*

**Тэмдэглэлтэй танилцсан:**

БАЙГАЛЬ ОРЧИН, ХҮНС,  
ХӨДӨӨ АЖ АХУЙН БАЙНГЫН  
ХОРООНЫ ДАРГА

Б.БЕЙСЕН

**Тэмдэглэл хөтөлсөн:**

ХУРАЛДААН ЗОХИОН БАЙГУУЛАХ  
ГАЗРЫН ШИНЖЭЭЧ

Д.УЯНГА

## **МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРАЛ**

2026 оны 06 дугаар сарын 10-ны өдөр,  
Лхагва гараг  
Төрийн ордон “Их засаг” танхим  
14 цаг 05 минут.

### **БАЙГАЛЬ ОРЧИН, ХҮНС, ХӨДӨӨ АЖ АХУЙН БАЙНГЫН ХОРООНЫ ХУРАЛДААНЫ ДЭЛГЭРЭНГҮЙ ТЭМДЭГЛЭЛ**

**Б.Бейсен:** Эрхэм гишүүдийн энэ өдрийн амар амгаланг айлтгая. Байнгын хорооны гишүүдийн олонх нь хүрэлцэн ирж, ирц 51.7 хувьтай бүрдсэн тул Байгаль орчин, хүнс, хөдөө аж ахуйн /БОХХАА/-н байнгын хорооны 2026 оны 6 дугаар сарын 10-ны өдрийн хуралдаан нээснийг мэдэгдье.

Монгол Улсын Их Хурал /УИХ/-ын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 7.8-д заасны дагуу хуралдааны ирцийг гишүүний сонгосон тойрог бүрээр танилцуулъя. Наранцэцэг Алтаншагай ирсэн байна, Пүрэвийн Батчимэг гишүүн ирсэн байна, Мөнгөнцогийн Ганхүлэг гишүүн ирсэн байна, Лувсанбямбаагийн Мөнхбаясгалан гишүүн ирсэн байна, Салдангийн Одонтуяа гишүүн ирсэн байна, Жигжидсүрэнгийн Чинбүрэн гишүүн ирсэн байна, Дашзэгвийн Амарбаясгалан гишүүн ирсэн байна, Буланы Бейсен гишүүн ирсэн байна, Мэндбаярын Мандхай гишүүн ирсэн байна, Тогтмолын Мөнхсайхан гишүүн ирсэн байна, Ухнаагийн Отгонбаяр гишүүн ирсэн байна, Бат-Өлзийн Бат-Эрдэнэ гишүүн ирсэн байна, Гомбын Ганбаатар гишүүн ирсэн байна, Цагаанхүүгийн Мөнхбат гишүүн ирсэн байна, Нанзадын Наранбаатар гишүүн ирсэн байна, Болдын Уянга гишүүн ирсэн байна.

Байнгын хорооны хуралдаанаар хэлэлцэх асуудлыг танилцуулъя. Хэлэлцэх асуудал 1.Хүнсний тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүд УИХ-ын гишүүн Мандхай нарын 10 гишүүн 2025 оны 6 сарын 19-ний өдөр өргөн мэдүүлсэн анхны хэлэлцүүлэг. 2.Хөдөө аж ахуйн тухай хуулийн төсөл УИХ-ын гишүүн Мандхай нарын 10 гишүүн 2025 оны 6 сарын 19-ний өдөр өргөн мэдүүлсэн эцсийн хэлэлцүүлэг. 3 дахь асуудал, Байнгын хорооны тогтоолын төсөл байсан. Уур амьсгалын өөрчлөлтийн тухай хуулийн төслийг Байнгын хорооны болон чуулганы нэгдсэн хуралдаанд хэлэлцүүлэх бэлтгэл хангах үүрэг бүхий ажлын хэсэг байгуулах тухай байсан. Энэ Их Хурлын даргын захирамжаар байгуулагдах эдийн засагтай холбоотой учраас манай Байнгын хорооны боловч тийм асуудалтай байгаа учраас энийг хасах саналтай байна. Гишүүд ямар саналтай байгаа бол?

3 дахь асуудлаа. Их Хурлын даргын захирамжаар байгуулах нь зөв юм шиг байна. Их Хурлын дарга манай ажлыг юутай холбоотой Их Хурлын даргын ажил гээд тэгсэн байна. Нөгөө талаар СОР-той холбоотой эдийн засгийн асуудал орох учраас олон салбарыг хамардаг юм байна. Тэгэхээр Их Хурлын даргын захирамжаар байгуулах нь зөв үү? Дэмжиж байвал, энэ өнөөдрийг хэлэлцэх асуудлаас хасъя. Хасъя гэдгээр горимын санал гаргая. Тэгээд та бүгд, тийм. Гишүүд санал хураалтад бэлдээрэй. Санал хураалт. Санал 75 хувиар дэмжигдсэн тул 3 дахь асуудлыг хэлэлцэх асуудлаас хаслаа.

Хэлэлцэх асуудлын талаар саналтай гишүүд байна уу? Байхгүй байна. Хэлэлцэх асуудалтай холбоотой хэлэлцэх асуудал байхгүй тул хэлэлцэх асуудалд оръё.

***Нэг.Хүнсний тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүд /Улсын Их Хурлын гишүүн М.Мандхай нарын 10 гишүүн 2025.06.19 -ний өдөр өргөн мэдүүлсэн, анхны хэлэлцүүлэг/***

Хүнсний тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслийн анхны хэлэлцүүлгийг явуулна. Хуралдаанд оролцож байгаа ажлын хэсгийн бүрэлдэхүүнийг танилцуулъя. Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн яам /ХХААХҮЯ/-ны Бодлого, төлөвлөлтийн газрын дарга Болорчулуун, Болорчулуун дуудаарай. Ч.Раднаабазар, ХХААХҮЯ-ны Хуулийн хэлтсийн дарга, О.Онон ХХААХҮЯ-ны Бодлого, төлөвлөлтийн газрын Салбарын нэгдсэн бодлого, төлөвлөлтийг хариуцсан ахлах шинжээч, байна уу? Х.Цэрэнханд ХХААХҮЯ-ны Бодлого, төлөвлөлтийн газрын Салбарын бодлого, төлөвлөлтийг хариуцсан ахлах мэргэжилтэн, М.Пүрэвжав Хүнсний эрдэм шинжилгээ, судалгааны хүрээлэнгийн захирал, Я.Хишигт хуульч, судлаач.

Хүнсний тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төсөл болон Байнгын хорооны болон чуулганы ирцийн хуралдаанд хэлэлцүүлэгт бэлтгэх үүрэг бүхий ажлын хэсэг Байнгын хорооноос байгуулагдан ажилласан. Төслийн анхны хэлэлцүүлэгт бэлтгэсэн талаарх танилцуулгыг ажлын хэсгийн ахлагч, УИХ-ын гишүүн Тогтмолын Мөнхсайхан танилцуулна. Мөнхсайхан гишүүний микрофон өгье.

**Т.Мөнхсайхан:** Байнгын хорооны дарга, эрхэм гишүүд ээ,

УИХ-ын гишүүн М.Мандхай нарын гишүүдээс 2025 оны 6 дугаар сарын 19-ний өдөр УИХ-д өргөн мэдүүлсэн Хүнсний тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүдийг 2025 оны 10 дугаар сарын 2-ны өдрийн чуулганы нэгдсэн хуралдаанаар хэлэлцэж, анхны хэлэлцүүлэгт бэлтгүүлэхээр БОХХАА-н байнгын хороонд шилжүүлсэн.

Байнгын хорооны 2025 оны 23 дугаар тогтоолоор хуулийн төслүүдийг Байнгын хороо болон чуулганы нэгдсэн хуралдаанаар хэлэлцүүлэх бэлтгэл хангах, санал, дүгнэлтийн төсөл боловсруулах үүрэг бүхий ажлын хэсгийг байгуулж, ажлын хэсгийн ахлагчаар УИХ-ын гишүүн Т.Мөнхсайхан, бүрэлдэхүүнд УИХ-ын гишүүн П.Батчимэг, Г.Ганбаатар, Н.Наранбаатар, А.Ундраа, Б.Уянга болон холбогдох бусад албан тушаалтнууд орж ажиллалаа.

Ажлын хэсэг энэ хугацаанд 4 удаа, мэргэжил арга зүйн туслалцаа үзүүлэх дэмжих баг 4 удаа хуралдаж, Хүнсний тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийн талаарх 17 саналын томьёолол бэлтгэж хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслийн талаарх 3 санал, төслийн бүтэц нэр, томьёо, хэл найруулга, дэс дараалал, зүйл заалтын дугаар, эшлэлийг нийцүүлж өөрчлөх нэг саналын томьёоллыг хэлэлцэн дэмжиж, БОХХАА байнгын хорооны хуралдаанд танилцуулах нь зүйтэй гэж үзсэн болно.

Тухайлбал, хоол үйлдвэрлэл, үйлчилгээ гэх нэр, томъёог стандартын шаардлага хангасан байр, түүхий эд, технологи болон мэргэжлийн хүний нөөцөд тулгуурлан хоол үйлдвэрлэх, үйлчлэх үйл ажиллагаа байхаар өөрчлөн найруулах. Төсөлд хүнсний аюулгүй байдал гэсэн нэр томъёог хасаж, тусад нь зүйл болгон томъёолсон байсныг Хууль тогтоомжийн тухай хуульд нэр томъёо нь нэг утга агуулгаар нийт хуулийн хэмжээнд хэрэглэгдэх бол түүний тодорхойлолтыг уг хуулийн нийтлэг үндэслэл гэсэн бүлэгт оруулан заана.

Мөн хуулийн төсөлд тодорхойлолт өгсөн хэд хэдэн нэр томъёо байгаа бол тэдгээрийг хуулийн нэр томъёоны тодорхойлолт гэсэн гарчигтай зүйлд нэгтгэнэ гэж заасны дагуу нэр томъёог холбогдох зүйлд хэвээр үлдээх. Хуулийн төслийн 4<sup>1</sup> дүгээр зүйлийн хүнсний аюулгүй байдлын бодлогын хэрэгжилтийг хангах тогтолцоо төсөлд тусгасан байдлаар хүнсний аюулгүй байдлыг хангах төлөвлөлт, зохион байгуулалтын шинжтэй асуудлыг хуульчлах нь агуулга, ач холбогдол бага бөгөөд харин хэн, хэрхэн, хэзээ, ямар журмаар хэрэгжүүлэх механизм байхгүй тунхгийн заалт болж үлдэх эрсдэлтэй байгаа тул төслөөс хасах.

Төслөөс баримтлах бодлогын хүрээнд цэцэрлэг, сургуулийн хүүхдийн хоолны үйлдвэрлэл дотоодын гарал үүсэлтэй түүхий эд ашиглан стандарт, техникийн зохицуулалтын шаардлага хангасан үйлдвэрт бэлтгэсэн хагас боловсруулсан болон бэлэн бүтээгдэхүүн нийлүүлсэн ААН хоршоог дэмжихээр тусгах. Салбар хоорондын үйл ажиллагааг уялдуулах зорилгоор мэдээллийн нэгдсэн санг үүсгэж эрхлэн хөтлөх. Уг сан нь хүнсний чиглэлийн үйл ажиллагаа эрхлэгчдийн бүртгэл, гол нэрийн хүнсний нөөцийн мэдээлэл, хяналт, шалгалтын тайлан, импорт, экспортын зөвшөөрөл, гүйцэтгэлийн мэдээлэл зэрэг 8 төрлийн мэдээллээс бүрдэх бөгөөд бусад төрийн байгууллагын системтэй цахимаар холбогдож мэдээллийг бүрдүүлэх талаар, стратегийн хүнсийг экспортлох, импортлох зөвшөөрөл олгохтой холбоотой журамласан зохицуулалтыг хэвээр хадгалж давхардлыг арилгах ААН-д учрах хүндрэл, чирэгдлийг бууруулах чиглэлээр хэсэгчилсэн өөрчлөлт хийх томъёоллыг ажлын хэсэг дэмжээгүй бөгөөд төсөл санаачлагчийн өргөн мэдүүлсэн хувилбарыг Зөвшөөрлийн тухай хуульд бүрэн нийцсэн гэж ажлын хэсэг үзсэн тул зохицуулалтыг төсөлд хэвээр үлдээх.

Ажлын хэсгээс аюулгүй байдал гэх нэр томъёог баталгаат байдал болгон хуулийн нэрийг өөрчлөх, нэр томъёог сууриар нь солих асуудал нь одоогийн нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийн хүрээнд өөрчлөх нь зөвхөн нэр томъёоны механик өөрчлөлт биш, харин бодлогын томоохон шинэчлэлд тооцогдох тул нэмэлт, өөрчлөлтийн хүрээнд шийдвэрлэх боломжгүй бөгөөд үүнийг нэг мөр солих нь салбарын бодлогыг бүхэлд нь шинэчлэн тодорхойлох хэмжээний зарчмын өөрчлөлт юм. Иймд аюулгүй байдал гэсэн нэр томъёог хэвээр үлдээж, цаашид хүнсний салбарын бодлогыг бүхэлд нь шинэчлэх тохиолдолд хуулийн шинэчилсэн найруулгыг боловсруулах замаар шийдвэрлэх нь зүйтэй гэж үзлээ. Мөн хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслийн нэр томъёоны өөрчлөлт хийх зарим хуулийн төслийг хууль санаачлагч татан авсан болно.

Хүнсний тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүдтэй холбогдуулан ажлын хэсгээс бэлтгэсэн зарчмын зөрүүтэй саналын томъёоллыг та бүхэнд тараасан болно.

Байнгын хорооны эрхэм гишүүд ээ, дээрх хуулийн төслүүдийг анхны хэлэлцүүлэгт бэлтгэсэн талаарх ажлын хэсгийн танилцуулга болон зарчмын

зөрүүтэй саналын томъёоллыг хэлэлцэн шийдвэрлэж өгөхийг та бүхнээсээ хүсье. Анхаарал хандуулсан явдалд баярлалаа.

**Б.Бейсен:** Монгол УИХ-ын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 39 дүгээр зүйлийн 39.10-д Байнгын хороо хуулийн төслийг зүйл бүрээр хэлэлцэнэ гэж заасны дагуу хэлэлцье. Гишүүд та бүхэн тухайн зүйлтэй холбогдуулан асуулт асууж болно. Асуулт асуух гишүүд нэрсээ өгнө үү? Хуулийн төслийн 1 дүгээр зүйлтэй холбогдуулан асуулт асуух гишүүд байна уу? Зүйл бүрээр нь. Мөнхбаясгалан гишүүнээр тасалъя. 1 дүгээр зүйлээр асуулт асуух гишүүд байхгүй юм байна. Ажлын хэсгээс 12 санал ирүүлсэн байгаа. Нэг бүрчлэн санал хураана. Гишүүд санал хураалтад бэлдээрэй.

Төслийн 1 дүгээр зүйлийн 1 дэх заалт буюу 3.1.15 дахь заалтыг доор дурдсан саналаар өөрчлөн найруулж, 3.1.14 дэх заалт болгож, 3.1.16 дахь заалтыг, мөн зүйлийн 2 дахь заалтыг тус тус хасах:

“3.1.14.“хоол үйлдвэрлэл, үйлчилгээ” гэж стандартын шаардлага хангасан байр, түүхий эд, бүтээгдэхүүн ашиглан, жор, технологийн дагуу техник, тоног төхөөрөмж, мэргэжлийн хүний нөөцөд тулгуурлан хоол үйлдвэрлэх, түүгээр үйлчлэх үйл ажиллагааг.” гэсэн байна. Санал хураалт. Санал 81.3 хувиар дэмжигдлээ.

Төслийн 1 дүгээр зүйлийн 4 дэх заалт буюу 4.2.1 дэх заалтын “хүртээмжийн” гэснийг “хүртээмж, дотоодын үйлдвэрлэлийн” гэж, 4.2.2 дахь заалтын “баталгаат” гэснийг “аюулгүй” гэж, 4.2.4 дэх заалтын “салбарын” гэснийг “аюулгүй байдлыг хангах” гэж өөрчилж, 4.3, 4.4 дэх хэсгийг хасах. Санал хураалт. Санал 75 хувиар дэмжигдлээ.

3 дахь санал хураалт. Төслийн 1 дүгээр зүйлийн 5 дахь заалтыг хасаж, мөн зүйлийн 4 дэх заалтад доор дурдсан агуулгатай 4.3 дахь хэсэг нэмэх:

“4.3.Энэ хуулийн 4.2 дахь хэсэгт заасан хүнсний аюулгүй байдлын бодлогыг удирдлага, зохион байгуулалт, хүний нөөц, мэдээлэл болон эрсдэлийн удирдлага, хяналтаар дамжуулан хэрэгжүүлнэ.” Санал хураалт. Санал 81.3 хувиар дэмжигдлээ.

4 дэх санал хураалт. Төслийн 6 дахь заалт буюу 4<sup>2</sup> дугаар зүйлийн 4<sup>2</sup>.1 дэх хэсгийн “мэргэшүүлэх, хөгжүүлэхэд,” гэснийг “мэргэшүүлэхэд” гэж, “хүнс, хөдөө аж ахуйн асуудал хариуцсан” гэснийг “хүнсний асуудал эрхэлсэн” гэж өөрчилж, “нөөцийн эрэлт хэрэгцээний судалгааг тогтмол хийж, хүний” гэснийг, 4<sup>2</sup>.2 дахь хэсгийн “боловсролын асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага,” гэснийг тус тус хасаж, 4<sup>2</sup>.3, 4<sup>2</sup>.4, 4<sup>2</sup>.5, 4<sup>2</sup>.7, 4<sup>2</sup>.8, 4<sup>2</sup>.9 дэх хэсгийг нэгтгэж, доор дурдсанаар өөрчлөн найруулж, 4<sup>2</sup> дугаар зүйлийн дугаарыг 13<sup>2</sup> дугаар зүйл гэж өөрчлөх.

“4<sup>2</sup>.3.Хүнсний салбарын мэргэжлийн зэрэг олгох журмыг хүнсний асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн батална.

4<sup>2</sup>.4.Энэ хуулийн 4<sup>2</sup>.3-т заасан журамд мэргэжлийн зэргийн төрөл, хэлбэр, хугацаа, мэргэшүүлэх чиглэл, тавих шаардлага, сургалтын багц цаг болон зэрэг

олгох, сунгах, түдгэлзүүлэх, сэргээх, хүчингүй болгохтой холбоотой харилцааг тусгана.

4<sup>2</sup>.5.Энэ хуулийн 4<sup>2</sup>.4-т заасан мэргэжлийн зэрэг олгох, сунгах, түдгэлзүүлэх, сэргээх, хүчингүй болгох шийдвэрийг хүнсний асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага гаргах бөгөөд мэргэжилтэн уг шийдвэрийн талаар хуульд заасан журмын дагуу гомдол гаргах эрхтэй.” Санал хураалт. Санал 68.8 хувиар дэмжигдлээ.

Дараагийн санал хураалт, 5 дахь санал хураалт. Төслийн 1 дүгээр зүйлийн 7 дахь заалт буюу 5.6 дахь хэсгийн “хүртээмжтэй байлгана” гэснийг “хүртээмжтэй байлгах арга хэмжээг Засгийн газар авч хэрэгжүүлнэ.” гэж өөрчилж, 5.5 дахь хэсгийг, 5.8 дахь заалтын “тусгайлсан” гэснийг тус тус хасах. Санал хураалт. Санал 68.8 хувиар дэмжигдлээ.

6 дахь санал хураалт. Төслийн 1 дүгээр зүйлийн 8, 9 дэх заалтыг тус тус хасах. Санал хураалт. Санал 75 хувиар дэмжигдлээ.

7 дахь санал хураалт. Төслийн 1 дүгээр зүйлийн 8.1.8 дахь заалтыг доор дурдсанаар өөрчлөн найруулах:

“8.1.8.цэцэрлэг, сургуулийн хүүхдийн хоол үйлдвэрлэлд дотоодын гарал үүсэлтэй түүхий эд ашиглан, стандарт, техникийн зохицуулалтын шаардлага хангасан үйлдвэрт бэлтгэсэн хагас боловсруулсан болон бэлэн бүтээгдэхүүн нийлүүлсэн аж ахуйн нэгж, хоршоонд;” гэж өөрчлөх юм байна. Санал хураалт. Санал 75 хувиар дэмжигдлээ.

8 дахь санал хураалт. Төслийн 1 дүгээр зүйлийн 10 дахь заалт буюу 10.5 дахь хэсгийг доор дурдсанаар өөрчлөн найруулж, 10.4.3 дахь заалт болгох:

“10.4.3.хүнсний экспорт, импорт, шошгололт, хадгалалт, хүргэлт, цахим болон бусад худалдаанд.” гэж өөрчлөх юм байна. Санал хураалт. Санал 75 хувиар дэмжигдлээ.

9.Төслийн 1 дүгээр зүйлийн 11 дэх заалт буюу 13.1.6 дахь заалтын “баталгаат” гэснийг “бүтээгдэхүүний аюулгүй” гэж өөрчилж, мөн зүйлийн 12 дахь заалтыг хасах. Санал хураалт. Санал 62.5 хувиар дэмжигдлээ.

10 дахь санал хураалт. Төслийн 1 дүгээр зүйлийн 13 дахь заалтын 13<sup>2</sup>.3.8 дахь заалтын “баталгаат” гэснийг “аюулгүй” гэж, “олон нийтэд сургалт, сурталчилгаа, соён гэгээрүүлэх” гэснийг “олон нийтийг соён гэгээрүүлэх сургалт, сурталчилгааны” гэж өөрчилж, 13<sup>2</sup>.3.9 дэх заалтын “таван жил” гэсний өмнө “гурваас” гэж нэмж, 13<sup>2</sup>.3.6 дахь заалтын “өндөр хөгжилтэй орны” гэснийг, 13<sup>2</sup>.3.7 дахь заалтын “мэргэжилтэн болон хүнсний чиглэлийн үйл ажиллагаа эрхэлдэг хуулийн этгээдийн” гэснийг, 13<sup>2</sup>.3.10 дахь заалтыг тус тус хасах. Санал хураалт. Санал хураалт 68.8 хувиар дэмжигдлээ.

11 дэх санал хураалт. Төслийн 1 дүгээр зүйлийн 14 дэх заалт буюу 17<sup>1</sup> дүгээр зүйлийг доор дурдсанаар өөрчлөн найруулах:

“17<sup>1</sup> дүгээр зүйл.Хүнсний салбарын мэдээллийн нэгдсэн сан

17<sup>1</sup>.1.Хүнсний асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага хүнсний аюулгүй байдлыг хангах, салбар хоорондын үйл ажиллагааг уялдуулан зохицуулах зорилгоор мэдээллийн нэгдсэн сан үүсгэж, эрхлэн хөтөлнө.

17<sup>1</sup>.2.Хүнсний салбарын мэдээллийн нэгдсэн сан нь дараах мэдээллээс бүрдэнэ:

17<sup>1</sup>.2.1.хүнсний чиглэлийн үйл ажиллагаа эрхлэгчийн бүртгэл;

17<sup>1</sup>.2.2.гол нэрийн хүнсний нөөцийн мэдээлэл;

17<sup>1</sup>.2.3.баяжуулагч бэлдмэл, хүнсний нэмэлт, өсгөврийн хөрөнгө, шинэ технологиор үйлдвэрлэсэн хүнс, хувиргасан амьд организмээс гаралтай хүнсний бүртгэл;

17<sup>1</sup>.2.4.хяналт, шалгалтын тайлан;

17<sup>1</sup>.2.5.импорт, экспортын зөвшөөрөл, гүйцэтгэлийн мэдээлэл;

17<sup>1</sup>.2.6.энэ хуулийн 17 дугаар зүйлд заасны дагуу баталгаажуулалт хийсэн талаарх мэдээлэл;

17<sup>1</sup>.2.7.хүнсний сорилтын лабораторийн шинжилгээний дүн;

17<sup>1</sup>.2.8.хүнсний салбарын эрдэм шинжилгээ, судалгааны ажлын тайлан.

17<sup>1</sup>.3.Төрийн болон бусад байгууллагатай цахим хэлбэрээр мэдээлэл солилцох, мэдээллийн санг бүрдүүлэх харилцааг Нийтийн мэдээллийн ил тод байдлын тухай хуулийн 18.10, 27.9-д заасны дагуу зохицуулна.

17<sup>1</sup>.4.Мэдээллийн нэгдсэн санг бүрдүүлэх, мэдээлэл ашиглах, цуглуулах, хэлбэр, хугацаа, мэдээллийн ил тод байдал, нууцлал, аюулгүй байдлыг хангах, хадгалах, хамгаалах, эрхлэн хөтлөхтэй холбогдсон журмыг Засгийн газар батална.” Санал хураалт. Санал 62.5 хувиар дэмжигдлээ.

2.хуулийн төслийн, 12.Дээрх 6 дахь санал дэмжигдсэнтэй холбогдуулан 1 дүгээр зүйлийн 15 дахь заалтыг хасах. Санал хураалт. Санал 56.3 хувиар дэмжигдлээ.

Хуулийн төслийн 2 дугаар зүйлтэй холбогдуулан асуулт асуух гишүүд нэрсээ өгнө үү? Асуулт асуух гишүүд байхгүй байна. Ажлын хэсгээс нэг санал ирүүлсэн байгаа. 13 дахь санал. Төслийн 2 дугаар зүйлийн 6 дугаар зүйлийн гэсний өмнө 5<sup>1</sup> дүгээр зүйлийн 5<sup>1</sup>7.4 дэх заалтын гэрээ гэсний дараа эсхүл харилцан тохиролцсон болохыг нотлох баримт бичиг гэж нэмж, 1 дүгээр зүйлийн зорилт нь гэсний дараа Хүнсний аюулгүй байдлыг хангаж хүний эрүүл мэндийг дэмжин хамгаалах зорилгоор гэж гэснийг, 9 дүгээр зүйлийн 9.3 дахь хэсгийн харилцаа гэсний дараа, буруу бичсэнээ өгчхөж. Уучлаарай энэ буруу юу өгчхөж.

Төслийн 2 дугаар зүйлийн “1 дүгээр зүйлийн “зорилт нь” гэсний дараа “хүнсний аюулгүй байдлыг хангаж, хүний эрүүл мэндийг дэмжин хамгаалах зорилгоор” гэж,” гэснийг, “, 9 дүгээр зүйлийн 9.3 дахь хэсгийн “харилцааг” гэсний дараа “тусгайлан” гэж гэж” гэснийг тус тус хасах. Санал хураалт. Хэн санал хураалтад ороогүй байна вэ? Отгонбаяр гишүүн горимын санал гаргаарай, гишүүд анхааралтай байгаарай.

**У.Отгонбаяр:** Сая техник гацах шиг боллоо. Тэгээд энэ санал хураалтыг цуцалж өгч, дахин санал хураалгана уу гэсэн горимын санал гаргаж байна.

**Б.Бейсен:** Отгонбаяр гишүүний горимын саналын дагуу саяын санал хураалтыг хүчингүй болгоё. Санал хураалт. Хүчингүй болгох санал 56.3 хувиар дэмжигдлээ. Түрүүчийн 13 дахь саналаар дахин санал хураалт явуулъя. Санал хураалт. Санал 56.3 хувиар дэмжигдлээ.

Хуулийн төслийн 3 дугаар зүйлтэй холбогдуулан асуулт асуух гишүүд нэрсээ өгнө үү? Асуулт асуух гишүүд байхгүй байна.

14 дэх санал хураалт. Төслийн 3 дугаар зүйлийн 5<sup>1</sup> дүгээр зүйлийн 5<sup>1.7</sup> дахь хэсгийн “дүгнэлтийг үндэслэн” гэснийг “санал, зөвлөмжийг харгалзан” гэж өөрчилж, 5<sup>1.6</sup> дахь хэсгийг хасах. Санал хураалт. Санал хураалт 56.3 хувиар дэмжигдлээ.

Хуулийн төслийн 4 дүгээр зүйлтэй холбогдуулан асуулт асуух гишүүд нэрсээ өгнө үү? Асуулт асуух гишүүд байхгүй байна.

Ажлын хэсгээс ирүүлсэн 1 санал байгаа. Дээрх 1, 2, 13 дахь санал дэмжигдсэнтэй холбогдуулан төслийн 4 дүгээр зүйлийг доор дурдсанаар өөрчлөн найруулах:

“4 дүгээр зүйл.Хүнсний тухай хуулийн 1 дүгээр зүйлийн 1.1 дэх хэсгийн “эрхлэхтэй” гэснийг “эрхлэх, түүнд хяналт тавихтай” гэж, 3 дугаар зүйлийн 3.1.8 дахь заалтын “үйлдвэрлэсэн” гэснийг “үйлдвэрлэсэн хүнс” гэж, “хийгдсэнийг” гэснийг “хийгдсэн хүнсийг” гэж, 4 дүгээр зүйлийн гарчгийн “зарчим” гэснийг “зарчим, бодлогын чиглэл” гэж, Хоёрдугаар бүлгийн гарчгийн “ХАНГАМЖ” гэснийг “ХАНГАМЖ, ХҮРТЭЭМЖ” гэж, 10 дугаар зүйлийн 10.1.5 дахь заалтын “боловсруулах болон нийтийн хоолны үйлдвэрлэл” гэснийг “хүнсний боловсруулах болон хоол үйлдвэрлэл, үйлчилгээ” гэж, 13 дугаар зүйлийн 13.1.1 дэх заалтын “шим тэжээллэг байдалд” гэснийг “шим тэжээллэг байдал, хуурамч хүнсний бүтээгдэхүүнд гэж” тус тус өөрчилсүгэй.” Санал хураалт. Санал 62.5 хувиар дэмжигдлээ.

5, хуулийн төслийн 5 дугаар зүйлтэй холбогдуулан асуулт асуух гишүүд нэрсээ өгнө үү? Асуулт асуух гишүүд байхгүй байна.

16.Дээрх 1, 2, 13, 14 дэх санал дэмжигдсэнтэй холбогдуулан төслийн 5 дугаар зүйлийг хасах. Санал хураалт. Санал 62.5 хувиар дэмжигдлээ.

6.Хуулийн төслийн 6 дугаар зүйлтэй холбогдуулан асуулт асуух гишүүд нэрсээ өгнө үү? Асуулт асуух гишүүд байхгүй байна.

17.Төслийн 6 дугаар зүйлийн “3 дугаар зүйлийн 3.1.2 дахь заалт, 4 дүгээр зүйлийн 4.1.1,” гэснийг хасах. Санал хураалт. Санал 62.5 хувиар дэмжигдлээ.

Найруулгын санал. 1.Төслийн талаарх зарчмын зөрүүтэй саналын томъёолол дэмжигдсэнтэй холбогдуулан төслийн бүтэц, нэр, томъёо, хэл найруулга, дэс дараалал, зүйл, заалтын дугаар, эшлэлийг нийцүүлж өөрчлөх. Санал хураалт. Найруулгын санал 62.5 хувиар дэмжигдлээ.

Одоо хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслийг зүйл бүрээр хэлэлцэнэ. Хүнсний бүтээгдэхүүний аюулгүй байдлыг хангах тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл. Хуулийн төслийн 1 дүгээр зүйлтэй холбогдуулан асуулт асуух гишүүд байна уу? Нэрсээ өгнө үү. Асуулт асуух гишүүд байхгүй байна. Хуулийн төслийн 2 дугаар, 1 санал байгаа юм байна.

Төслийн 1 дүгээр зүйлийн 1 дэх заалтын 4.1.4 дэх заалтын “хүнсний баталгаат байдал” гэснийг “хүнсний түүхий эд, бүтээгдэхүүний аюулгүй байдал” гэж өөрчлөх. Санал хураалт. Санал 56.3 хувиар дэмжигдлээ.

Хуулийн төслийн 2 дугаар зүйлтэй холбогдуулан асуулт асуух гишүүд нэрсээ өгнө үү? Асуулт асуух гишүүд байхгүй байна. Ажлын хэсгээс ирүүлсэн 1 санал байгаа.

2.Төслийн 2 дугаар зүйлийг хасах. Санал хураалт. Санал 62.5 хувиар дэмжигдлээ.

Зөрчлийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийн 1 дүгээр зүйлтэй холбогдуулан асуулт асуух гишүүд байна уу? Нэрсээ өгнө үү. Асуулт асуух гишүүд байхгүй байна. Ажлын хэсгээс ирүүлсэн 1 санал байгаа.

1.Төслийн 1 дүгээр зүйлийн “, 6.15 дугаар зүйлийн гарчгийн “Хүнсний бүтээгдэхүүний аюулгүй байдлыг хангах” гэснийг “Хүнсний бүтээгдэхүүний баталгаат байдлыг хангах” гэж, 13.9 дүгээр зүйлийн 2 дахь хэсгийн “бүтээгдэхүүний аюулгүй байдал” гэснийг “бүтээгдэхүүний баталгаат байдал” гэж тус тус” гэснийг хасах. Санал хураалт. Санал хураалт 62.5 хувиар дэмжигдлээ.

Хуулийн төслийн 2 дугаар зүйлтэй холбогдуулан асуулт асуух гишүүд нэрсээ өгнө үү? Асуулт асуух гишүүд байхгүй байна. Хүнсний тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслийг зүйл бүрээр хэлэлцэж дууслаа. Төслийн анхны хэлэлцүүлгийг явуулсан талаар БОХХАА-н байнгын хорооноос гарсан санал, дүгнэлтийг УИХ-ын гишүүн Тогтмолын Мөнхсайхан чуулганы нэгдсэн хуралдаанд танилцуулна.

14.40 цаг

***Хоёр.Хөдөө аж ахуйн тухай хуулийн төсөл /Улсын Их Хурлын гишүүн М.Мандхай нарын 10 гишүүн 2025.06.19-ний өдөр өргөн мэдүүлсэн, эцсийн хэлэлцүүлэг/***

Дараагийн асуудалд оръё. Хэлэлцэж байгаа асуудалтай холбогдуулан хуралдаанд оролцож байгаа албан тушаалтнуудыг танилцуулъя. ХХААХҮЯ-наас

Ц.Болорчулуун ХХААХҮЯ-ны Бодлого, төлөвлөлтийн газрын дарга, Ч.Раднаабазар ХХААХҮЯ-ны Хуулийн хэлтсийн дарга.

Хөдөө аж ахуйн тухай хуулийн төслийн эцсийн хэлэлцүүлгийг явуулна. Эцсийн хэлэлцүүлэгт бэлтгэгдсэн талаарх танилцуулгыг ажлын хэсгийн гишүүн Наранбаатар танилцуулна.

**Н.Наранбаатар:** Байнгын хорооны дарга, эрхэм гишүүд ээ,

Монгол УИХ-ын гишүүн М.Мандхай нарын 10 гишүүнээс 2025 оны 6 дугаар сарын 19-ний өдөр УИХ-д өргөн мэдүүлсэн Хөдөө аж ахуйн тухай хуулийн төслийн анхны хэлэлцүүлгийг УИХ-ын чуулганы 2026 оны 6 дугаар сарын 5-ны өдрийн нэгдсэн хуралдаанаар явуулж, эцсийн хэлэлцүүлэгт бэлтгүүлэхээр БОХХАА-н байнгын хороонд шилжүүлсэн билээ.

БОХХАА-н байнгын хороо 2026 оны 6 дугаар сарын 10-ны өдрийн хуралдаанаараа дээрх хуулийн төслийн эцсийн хэлэлцүүлгийг Монгол УИХ-ын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 42 дугаар зүйлийг баримтлан явуулахаар бэлтгэлээ. УИХ-ын чуулганы нэгдсэн хуралдааны анхны хэлэлцүүлгээр олонхын дэмжлэг авсан саналыг төсөлд нэмж тусган, хуулийн төслийг эцсийн хэлэлцүүлэгт бэлтгэсэн төсөл болон хуулийн төслийг эцсийн хэлэлцүүлэгт бэлтгэсэн тухай танилцуулгыг та бүхэнд хүргүүлсэн болно.

Байнгын хорооны эрхэм гишүүд ээ,

ХАА-н тухай хуулийн төслийг эцсийн хэлэлцүүлэгт бэлтгэсэн төсөл болон хуулийн төслийг эцсийн хэлэлцүүлэгт бэлтгэсэн тухай танилцуулгыг хэлэлцэн шийдвэрлэж өгөхийг та бүхнээс хүсье. Анхаарал тавьсанд баярлалаа.

**Б.Бейсен:** Наранбаатар гишүүнд баярлалаа. Ажлын хэсгийн танилцуулгатай холбогдуулан асуулт асуух гишүүд байна уу, нэрсээ өгнө үү? Байхгүй байна. Хөдөө аж ахуйн тухай хуулийн төслийн эцсийн хэлэлцүүлэг явуулж дууслаа. Төслийн эцсийн хэлэлцүүлгийг явуулсан талаарх БОХХАА-н байнгын хорооноос гаргах танилцуулгыг УИХ-ын гишүүн Нанзадын Наранбаатар чуулганы нэгдсэн хуралдаанд танилцуулна.

14.43 цаг

Эцсийн хэлэлцүүлэг, түрүүн хэлсэн. Байнгын хорооны хуралдаанаар хэлэлцэх асуудал дууссан тул хуралдаан хаасныг мэдэгдье. Байнгын хорооны гишүүд, ажлын хэсгийнхэнд баярлалаа.

ДУУНЫ БИЧЛЭГЭЭС ХУРАЛДААНЫ  
ДЭЛГЭРЭНГҮЙ ТЭМДЭГЛЭЛ БУУЛГАЖ,  
ХЯНАСАН: ШИНЖЭЭЧ

Д.УЯНГА